

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дэх заалт, Төрийн албан тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/539 дүгээр захирамжаар батлагдсан Орон сууцны бодлогын газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан нийслэл хот болон гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хот дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу хэрэгжүүлэхээр даалгасан, түүний нөлөөлөлд өртсөн эзэмшигч, өмчлөгч этгээдийг түр суурьшуулах орон сууцаар хангах, нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий шинээр байгуулагдсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажилагаанд шаардагдах мэдээ, мэдээллийг бэлтгэх, төслийн байршлийг тодруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Бодлогын төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Орон сууцны судалгаа хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичиг:	Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн

2.Энэ тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт орсон албан хаагчдын илүү цагийн хөлсийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу тооцож олгохыг ахлах нягтлан бодогч (Ю.Нанжид)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ГАНХҮҮ

